

Кампилобактериоз гэж юу вэ?

Шигеллоз нь *Шигелла* хэмээх нянгаар үүсгэгддэг халдвар юм. Шигелла нь суулгалт өвчний нийтлэг шалтгаан юм.

Хэнд халдварладаг вэ?

Шигеллоз хэнд ч халдварлаж болох боловч дараах хүмүүс хамгийн түгээмэл байдлаар халдвар авдаг:

- 5-аас доош насны хүүхдүүд
- Хүүхэд асрах төвийн хүүхдүүд
- Ариун цэврийн шаардлага хангаагүй, баталгаагүй хоол хүнс, устай газар луу зорчиж байгаа хүмүүс
- Орон гэргүй хүмүүс
- Эрчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрчүүд

Энэ нь хэрхэн тархдаг вэ?

Шигеллозоор өвчилсөн хүн, амьтны ялгадас (өтгөн)-ны өчүүхэн хэсэг санамсаргүйгээр аманд орох үед шигеллозоор өвчилдөг.

Шигеллоз нь амархан тархдаг, ялангуяа дараах газруудад:

- Ариун цэвэр муу
- Олуулаа амьдардаг газар
- Бохирдсон хоол хүнс эсвэл ус

Хүн дараах байдлаар өвдөж болно:

- Халдвар авсан хүнтэй шууд харьцах. Өвдсөн хүнийг асрах эсвэл живх солих гэх мэт.
- Бохирдсон хоол эсвэл уух зүйл хэрэглэх
- Бохирдсон зүйлд хүрэх, дараа нь угаагаагүй гараараа амандаа хийх
- Хүмүүс сэлдэг цөөрөм эсвэл нуур гэх мэт цэвэр биш эсвэл аюулгүй бус ус залгих
- Бэлгийн харьцааны үед ялгадас хүрэх

Ямар шинж тэмдэг илэрдэг вэ?

- Бага зэргийн болон хүнд хэлбэрийн суулгалт, заримдаа цус эсвэл салстай гарах
- Халуурах
- Дотор муухайрах болон бөөлжих
- Зарим хүмүүст ямар ч шинж тэмдэг илэрдэггүй

Ихэвчлэн нянгийн халдвар авснаас хойш 1-3 хоногийн дараа шинж тэмдэг илэрч эхэлдэг бөгөөд долоо хоног орчим үргэлжилдэг.

Хэрхэн оношилдог вэ?

Лабораторийн шинжилгээгээр өтгөнд шигелла илрүүлэх боломжтой.

Ямар эмчилгээ хийдэг вэ?

Ихэнх хүмүүс эдгэрэхийн тулд эм хэрэглэх шаардлагагүй. Хүмүүс шингэний дутагдалд орохгүй байхын тулд шингэн зүйл уух хэрэгтэй. Хүнд өвчтэй хүмүүс антибиотик хэрэглэх шаардлагатай байж болно. Тухайн хүнд антибиотик шаардлагатай эсэхийг эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч шийднэ.

Үүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх вэ?

- Дараах тохиолдолд гараа тогтмол дор хаяж 20 секунд савандаж угаах хэрэгтэй:
 - Ариун цэврийн өрөөнд орсон эсвэл живх сольсны дараа
 - Хоол хүнс бэлтгэх болон идэхээс өмнө
 - Бэлгийн харьцааны өмнө болон дараа
- Аюултай байж болзошгүй ус (жишээ нь, цөөрөм, нуур, усан сангаас ус) үүж болохгүй.
- Суулгалт дууссаны дараа бэлгийн харьцаанд орохын тулд багадаа 2 долоо хоног хүлээх хэрэгтэй
- Хэрэв олон улсад аялж байгаа бол аюулгүй идэх болон уух зуршлыг дагаж мөрдөөрэй

Халдвар авсан хүн хэр удаан халдвар тээдэг вэ?

Хүмүүс шигеллозын шинж тэмдэг зогссоноос хойш 2 долоо хоног хүртэл халдвар тараадаг.

Халдвар авсан хүн гэртээ хэр удаан байх ёстой вэ?

Суулгаж байгаа хүн суулгалт нь зогсолт гэртээ байх ёстой. Зарим хүмүүс ажил, сургуульдаа хэзээ буцаж очих талаар дараах хүмүүсийг багтаан эрүүл мэндийн газраас асууж лавлах ёстой:

- Хоол боловсруулагчид
- Эрүүл мэндийн ажилтнууд
- Хүүхэд асардаг ажилчид
- Хүүхэд харах үйлчилгээнд хамрагддаг хүүхдүүд

Зарим хүмүүс өтгөнд нь нян байхгүй болтол ажилдаа явах эсвэл хүүхэд асрах боломжгүй байна.

Би хэрхэн нэмэлт мэдээлэл авах вэ?

- Шигеллозын талаар асууж лавлах зүйл байвал эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчтэйгээ холбогдоно уу.
- Хоол хүнсээр дамжих өвчний талаар асуухыг хүсвэл Арлингтон Дүүргийн Олон нийтийн эрүүл мэндийн халдварт өвчний хөтөлбөрийн вебсайтад зочилно уу
(<https://www.arlingtonva.us/Government/Programs/Health/Public-Health/Communicable-Disease-Programs>).
- Хоол хүнсээр дамжих өвчний талаар мэдээлэхийн тулд "My Meal Detective" вебсайтад зочилно уу
(<https://redcap.vdh.virginia.gov/redcap/surveys/?s=PJACE4A4EY>).
- Шигелла нянгийн талаар нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл ӨХУСТ-ийн вебсайтад
(<https://www.cdc.gov/shigella>) зочилно уу.



ARLINGTON
VIRGINIA

Public Health

2100 Вашингтон Бульвард
Арлингтон, VA 22204

703-228-5200 утсаар залгаж, #1 сонголт хийж, Өдрийн
сувилагчаас асууна уу.

www.arlingtonva.us